



АРХАНГАЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: АРА-2024/01/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас: www.audit.mn Цэцэрлэг хот 2024 оны 04 дүгээр сарын 20	Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn
	Аудитын менежер: Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn
	Ахлах аудитор: Н.Алтантуяа Утас: 99338611 Цахим хаяг: Altantuyan@audit.gov.mn
	Аудитор: Л.Соёлмөнх Утас: 99051581 Цахим хаяг: Soyolmunkhl@audit.gov.mn
	Аудитор: А.Пүрэвцэцэг Утас: 99746363 Цахим хаяг: Purewtsetsega@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2024.04.16 № 174

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Архангай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн нэгтгэсэн тайланд санхүүгийн аудит хийлээ.

Архангай аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төсвийн жилд инфляцийн сөрөг нөлөөллийг багасгаж, төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг нэмэгдүүлэх чиглэлээр Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоол, Архангай аймгийн Засаг даргын А/74 дүгээр захирамжийн дагуу төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбоотой төсөвт тодотгол хийгдэж цалингийн сан 4,958.3 сая төгрөгөөр нэмэгдэж, төсөв 24.4 хувиар тэлсэн байна.

Аудитын гол асуудал

Аймгийн 2023 оны санхүүгийн дэмжлэгээс 400.0 сая төгрөгийг, Төсвийн тухай хуулийн 23 дугаар 23.6.1-д зааснаар аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогоос 202.3 сая төгрөгийг Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр

2004-2010 онуудад нийтийн аж ахуйг сайжруулах 2 үе шаттай төслийн хүрээнд хэрэгжсэн /Архангай аймгийн ЗДТГ OL-1907MON-08 зээлийн гэрээ/ дамжуулан зээлдүүлэх гэрээний зээл, зээлийн хүүгийн төлбөрт нийт 602.3 сая төгрөгийг төлсөн байна.

Бусад асуудлын хэсэг

Архангай аймгийн Засаг дарга нь 2023 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 5 үндсэн зорилтын 166 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс хяналтыг хэрэгжүүлж **90.9** хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Т.БАЙГАЛМАА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН БАЙДЛЫН ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(мянган төгрөгөөр)

Код	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	24,894,993.33	28,833,159.06
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	15,735,438.52	19,234,188.38
33	АВЛАГА	6,901,725.77	7,114,855.13
34	УРЬДЧИЛГАА	315.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,856,852.32	2,048,285.37
36	НӨӨЦИЙН БАРАА	325,653.90	360,822.36
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	75,007.82	75,007.82
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	105,930,896.93	109,086,177.04
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	105,930,896.93	109,086,177.04
39200	Биет хөрөнгө	100,209,682.48	103,429,834.36
39300	Биет бус хөрөнгө	5,495,393.25	5,542,302.75
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	225,821.21	114,039.93
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	130,825,890.26	137,919,336.10
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	12,449,912.35	12,382,090.83
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	394,665.57	499,416.49
41300	Өглөг	280,547.44	385,754.62
41400	Урьдчилж орсон орлого	114,118.13	113,661.87
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	12,055,246.78	11,882,674.34
42200	Урт хугацаат зээл	12,055,246.78	11,882,674.34
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	118,375,977.91	125,537,245.27
51	Засгийн газрын хувь оролцоо	118,375,977.91	125,537,245.27
51100	Засгийн газрын оруулсан капитал	15,567,521.61	15,558,087.91
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	4,834,538.88	4,831,029.98
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	3,414,850.89	3,591,589.49
51200	Хуримтлагдсан үр дүн	86,323,385.02	93,365,854.79
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	8,235,681.51	8,190,683.09
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	130,825,890.26	137,919,336.10

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	84,833,536.78	143,412,778.43
11	ТАТВАРЫН ОРЛОГО	16,104,609.73	18,778,856.55
110	Орлогын албан татвар	9,294,019.00	12,919,493.76
1100	Хувь хүний орлогын албан татвар	9,604,634.02	12,492,953.28
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(635,030.83)	(804,131.86)
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	845.20	8,415.40
1103	ААН-ын орлогын албан татвар	323,570.61	1,222,256.95
113	Хөрөнгийн албан татвар	2,597,381.00	2,819,192.39
118	Бусад татвар, төлбөр, хураамж	4,213,209.73	3,040,170.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	44,895,809.44	51,666,386.72
120	Нийтлэг татварын бус орлого	22,517,887.39	19,819,704.63
121	Хөрөнгийн орлого	109,378.90	116,400.00
122	Тусламжийн орлого	62,229.16	60,287.50
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	22,206,313.99	31,669,994.59
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	23,833,117.61	72,967,535.16
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	42,608,933.07	49,216,625.81
21	УРСГАЛ ЗАРДАЛ	41,164,599.83	47,521,166.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	38,894,291.32	46,655,937.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	11,406,044.16	14,945,511.24
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,495,843.20	1,922,299.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,026,484.91	1,189,347.40
2104	Хангамж, бараа материалын зардал	1,131,715.01	1,507,514.03
2105	Нормативт зардал	313,663.47	217,169.31
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	932,122.37	588,827.04
2107	Томилолт, зочны зардал	162,823.35	292,347.10
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,982,646.29	13,559,282.36
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	11,442,948.55	12,433,639.87
212	ТАТААС	89,120.32	107,800.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,181,188.20	757,428.58
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,444,333.23	1,695,459.60
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	42,224,603.71	94,196,152.62
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	4,860.00	0.00
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	164,680,504.69	87,516,121.59
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(122,451,040.98)	6,680,031.03

2.3 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	71,177,992.76	136,591,868.74
11	ТАТВАРЫН ОРЛОГО	16,104,489.73	18,778,856.55
110	Орлогын албан татвар	9,294,348.90	12,919,493.76
1100	Хувь хүний орлогын албан татвар	9,604,963.92	12,492,953.28
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(635,030.83)	(804,131.86)
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	845.20	8,415.40
1103	ААН-ын орлогын албан татвар	323,570.61	1,222,256.95
113	Хөрөнгийн албан татвар	2,596,931.10	2,819,192.39
118	Бусад татвар, төлбөр, хураамж	4,213,209.73	3,040,170.40
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	569,016.85	832,645.13
1181	Газрын төлбөр	1,195,302.21	902,541.07
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	2,448,890.67	1,304,984.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	31,102,940.18	44,916,334.85
120	Нийтлэг татварын бус орлого	8,753,747.29	13,127,352.76
121	Хөрөнгийн орлого	109,378.90	116,400.00
122	Тусламжийн орлого	33,500.00	2,587.50
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	22,206,313.99	31,669,994.59
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	23,970,562.85	72,896,677.34
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	34,534,877.44	41,487,702.85
21	УРСГАЛ ЗАРДАЛ	34,534,877.44	41,487,702.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	32,270,151.54	40,620,342.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	12,033,972.34	15,740,214.03
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,694,938.38	2,198,640.90
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,276,696.91	1,502,964.44
2104	Хангамж, бараа материалын зардал	1,428,242.21	2,128,135.21
2105	Нормативт зардал	185,045.20	58,359.73
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	911,075.22	615,075.10
2107	Томилолт, зочны зардал	151,009.35	301,836.03
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,042,304.24	13,795,450.66
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,546,867.68	4,279,666.12
211	ХҮҮ	8,000.00	0.00
212	ТАТААС	89,580.32	108,164.76
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,167,145.59	759,195.88
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	36,643,115.32	95,104,165.90
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	9,058.36	0.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	37,453,321.30	89,193,871.19
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	37,453,321.30	89,193,871.19
2200	Дотоод эх үүсвэрээр	37,453,321.30	89,193,871.19
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(37,444,262.94)	(89,193,871.19)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(2,585,859.13)	(2,411,544.85)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	2,585,103.80	2,411,544.85
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	755.33	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(3,387,006.75)	3,498,749.86

101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	19,122,445.27	15,735,438.52
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	15,735,438.52	19,234,188.38

2.4 АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	240,586,890.50	240,586,890.50
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	61,414.26	61,414.26
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	240,648,304.77	240,648,304.77
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(3,888.88)	(3,888.88)
7	Өмчид гарсан өөрчлөлт	182,603.00	182,603.00
9	Тайлант үеийн үр дүн	(122,451,040.97)	(122,451,040.97)
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	118,375,977.91	118,375,977.91
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	118,375,977.91	118,375,977.91
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	362,438.74	362,438.74
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	118,738,416.65	118,738,416.65
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(44,998.42)	(44,998.42)
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(3,508.90)	(3,508.90)
17	Өмчид гарсан өөрчлөлт	167,304.90	167,304.90
19	Тайлант үеийн үр дүн	6,680,031.02	6,680,031.02
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	125,537,245.26	125,537,245.26

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт хэмнэлт	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	64,892,514.90	55,072,675.79	9,819,839.11	84.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	38,880,782.10	36,458,425.10	2,422,357.00	93.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	37,930,908.20	35,643,068.76	2,287,839.44	93.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	14,429,092.00	13,953,049.94	476,042.06	96.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,870,526.40	1,794,015.73	76,510.67	95.91
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,600,850.10	8,798,479.85	802,370.25	91.64
2104	Хангамж, бараа материалын зардал	1,161,031.50	1,125,487.18	35,544.32	96.94
2105	Нормативт зардал	19,700.00	17,608.00	2,092.00	89.38
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,675,605.00	2,623,097.93	52,507.07	98.04
2107	Томилолт, зочны зардал	304,964.80	287,411.29	17,553.51	94.24
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил,	3,477,043.60	3,052,146.69	424,896.91	87.78

	үйлчилгээний төлбөр, хураамж				
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,392,094.80	3,991,772.16	400,322.64	90.89
212	ТАТААС	126,965.30	108,164.76	18,800.54	85.19
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	18,800.00	0.00	18,800.00	0.00
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	108,165.30	108,164.76	0.54	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	822,908.60	707,191.58	115,717.02	85.94
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	180,500.00	149,000.00	31,500.00	82.55
2132	Бусад урсгал шилжүүлэг	642,408.60	558,191.58	84,217.02	86.89
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	20,283,704.60	16,202,705.85	4,080,998.75	79.88
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	5,728,028.20	2,411,544.85	3,316,483.35	42.10
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	64,892,514.90	55,381,132.08	9,511,382.82	85.34
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	51,483,640.60	52,969,666.61	-1,486,026.01	102.89
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	13,408,874.30	2,411,465.47	10,997,408.83	17.98
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	4,726,892.45	-4,726,892.45	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	4,858,161.98	-4,858,161.98	0.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	781.00	770.00	11.00	98.59
620001	Удирдах ажилтан	168.00	166.00	2.00	98.81
620002	Гүйцэтгэх ажилтан	413.00	402.00	11.00	97.34
620003	Үйлчлэх ажилтан	170.00	170.00	0.00	100.00
620004	Гэрээт ажилтан	30.00	32.00	-2.00	106.67

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,176,488.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,100,666.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,039,027.62
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	25,589.92
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,275.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	48,236.02
2105	Нормативт зардал	9,785.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	45,184.50
2107	Томилолт, зочны зардал	4,387.38
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	440,190.18
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	425,821.76
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	61,639.29
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,400.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	57,239.29
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	75,821.80
2200	Дотоод эх үүсвэрээр	75,821.80
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,176,488.72
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,176,488.72
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

4.2.1 ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Архангай аймгийн Засаг дарга нь тайлант хугацаанд шилэн дансны цахим системд 5 мэдээллийг хугацаа хоцроон, 3 мэдээллийг огт байршуулаагүй, төсөв, өмч хөрөнгө зарцуулахтай холбоотой нийт 7,181.7 сая төгрөгийн 85 шийдвэрүүдийг бүрэн мэдээлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна. Үүнд Замын сангийн 1,055.3 сая төгрөгийн 6 шийдвэр, ОНХО-ын 1,543.6 сая төгрөгийн 33 шийдвэр, ОНХС-ийн 4,325.0 сая төгрөгийн 32 шийдвэр, гамшгийн 257.8 сая төгрөгийн 14 шийдвэр байна.

Хүснэгт 21. Шилэн дансны мэдээлэл

д/д	хугацаа	төрөл	удаа	хугацаанд нь мэдээлсэн	хугацаа хоцроосон	Мэдээлээгүй	Хоцроосон мэдээлэл
1	Бүтэн жил	13	13	12	-	1	Худалдан авах ажиллагааны тайланг огт мэдээлээгүй байна.
2	Хагас жил	3	3	2	1	-	Хагас жилийн санхүүгийн тайланг хугацаа хоцроон мэдээлсэн.
3	Улирал бүр	2	8	8	-	-	
4	Сар бүр	5	60	54	4	2	ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэл 3,7 саруудад хоцроож, 12 сарын мэдээллийг огт мэдээлээгүй, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл 12 сарын мэдээллийг огт мэдээлээгүй, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөв, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл 3, 4 саруудад мэдээллийг хоцроосон.
5	Тухай бүр	5	60	60	-	-	
НИИТ		29	144	136	5	3	

Эх сурвалж. Архангай аймгийн ТЕЗ-ийн шилэн дансны цахим хуудас

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1-6.10-д заасан “төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ ...” гэсэн заалтуудыг зөрчсөн, зөрчлийг давтан гаргасан байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй давтан гаргасан тул холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлагыг хүргүүлээ.

5. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт **656.5** сая төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад **656.5** сая төгрөгийн 2 алдааг залрууллаа.

5.1 ЗАЛРУУЛГА

Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд **656.5** сая төгрөгийн дараах залруулгыг аудитын явцад хийлгэлээ. Үүнд:

- ✓ Нэгдсэн тайлангийн санхүүгийн байдлын тайланд Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээлийн авлагыг гадаадын зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлагаар 187.6 сая, дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлагаар 224.1 сая, нийт **411.7** сая төгрөгийн авлагын үлдэгдлийг буруу ангилан бүртгэснийг аудитын явцад залруулж бүртгүүлэв.
- ✓ Санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь авлагын дансны тодруулгаар Э тайланд тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй авлагын үлдэгдлийг **244.8** сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг аудитын явцад залруулж бүртгүүлэв.

Аудитаар нийт 308.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 308.8 сая төгрөгийн зөрчилд 2 албан

шаардлага хүргүүлж, 5 зөвлөмж өгч, шилэн данстай холбоотой зөрчил гаргасан 1 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүллээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар илэрсэн 308.8 сая төгрөгийн зөрчлийг материаллаг гэж үнэлснээс гадна санхүүгийн тайланд нэгтгэгдсэн харьяа байгууллагуудын зөрчлийн нөлөөллийг үнэлж нийт 529.7 сая төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд нөлөөлөх материаллаг гэж үнэлснээр нийт материаллаг зөрчлийн дүн **838.5 сая төгрөг болсон**. Энэ нь аудитын төлөвлөлтийн үе шатанд тооцсон гүйцэтгэлийн материаллаг байдал 957.1 сая төгрөгийн түвшинд байх тул “Өөрчлөлтгүй” санал дүгнэлтийг хүргүүллээ.

1.1 АЛБАН ШААРДЛАГА

1. Санхүүгийн нэгтгэсэн тайланд **118.8 сая төгрөгийн** авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, авлагын насжилт болон хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг зөрүүтэй бүртгэсэн зэргээр нягтлан бодогч нар нь Сангийн яамны Э-тайланд авлагын тодруулгыг үнэн зөв бүртгэж тайлагнаагүй байхад түүнд хяналт тавьж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3. дахь “Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн гүйцэтгэл болон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу гаргана.” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.9. дахь “аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Сангийн яамны Э-тайланд авлагын тодруулга тайланг буруу бүртгэсэн зөрчлийг арилгаж цаашид үнэн зөв бүртгэж байгаа эсэхэд тавих хяналтыг сайжруулах албан шаардлагыг хүргүүллээ.

2. Тайлант онд “Цөм сүрэг үржлийн төв” ОНӨААТҮГ нь 2022, 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-т заасны дагуу Төрийн аудитын газарт холбогдох анхан шатны баримтын хамт ирүүлээгүйн улмаас хангалттай зохистой нотолгоо олж авах боломжгүй байсан тул дүгнэлт өгөхөөс татгалзсан, тус байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй **190.0 сая төгрөгийн** мал амьтдын үлдэгдлийг сүүлийн 2 жилд тоолж баталгаажуулаагүй, бодитоор оршин байгаа эсэх нь тодорхойгүй, бүртгэлээр тавих хяналт алдагдсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.49. дэх “дотоод аудит” гэж төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн төсвийн дотоод хяналтын үйл ажиллагааг”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д “төрийн болон орон нутгийн өмчит төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 03 дугаар сарын 15-ны дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч болон Төрийн өмчийн хороонд хүргүүлэх» гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: “Цөм сүргийн үржлийн төв” ОНӨААТҮГ-ын хөрөнгөд бүртгэлтэй мал амьтадыг тоолж, баталгаажуулан, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, бүтэц зохион байгуулалтад өөрчлөх арга хэмжээг авч ажиллах албан шаардлагыг хүргүүллээ.

5.3 АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

5.3.1 ДОТООД ХЯНАЛТ ХАРИУЦЛАГАТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

Илрүүлэлт: Аймгийн ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээнд жил бүр санхүүгийн хяналт аудитын албанаас дотоод аудитыг хэрэгжүүлж байгаа хэдий ч цалингийн сангаас зориулалт бус зарцуулалт гаргасан, нягтлан бодох бүртгэлийг алдаатай бүртгэсэн зэрэг нийтлэг алдаа зөрчил давтагдан гарч байгаагаас үзэхэд дотоод аудитын хэрэгжилт үр дүн хангалтгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.49 дэх "дотоод аудит" гэж төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн төсвийн дотоод хяналтын үйл ажиллагааг" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн хяналт аудитын албаны дотоод аудит, хяналт шалгалтыг тайлант оны үйл ажиллагаа руу түлхүү чиглүүлэх, төсөвт байгууллагын дотоод аудитын үр дүн, үр нөлөөг сайжруулах арга хэмжээ авах зөвлөмж өгөх

5.3.2 АРВИЛАН ХЭМНЭЛТ, ҮР АШИГ, ҮР НӨЛӨӨТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

Илрүүлэлт: Аудитад аймгийн хэмжээний 9 ОНӨААТҮГ-ыг хамруулснаас "Цөм сүргийн үжлийн төв", "Ар саравч" ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөхөөс татгалзаад байна. Түүнчлэн "Ар-Ус Ундарга" ОНӨХХК нь 154.9 сая төгрөгийн, "Архангайд үйлдвэрлэв" ОНӨААТҮГ нь 66.7 сая төгрөгийн, "Чулуут ахуйн үйлчилгээний төв" нь 24.0 сая төгрөгийн, "Эрдэнэмандал шилмэл сүргийн үржлийн төв" ОНӨААТҮГ нь 15.1 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.2 "эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, хүргэх түвшин", 20 дугаар зүйлийн 20.3 "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Архангай аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эдийн засгийн зорилтод түвшин, үр ашигт ажиллагаа, дотоод засаглал, үндсэн үйл ажиллагааны үр дүн, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үүрэг хариуцлагыг сайжруулан, үр ашигтай ажиллах менежментийн төлөвлөгөө батлан, хэрэгжилтийг тайлагнах

5.3.3 ДОТООД ХЯНАЛТ ХАРИУЦЛАГАТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

Илрүүлэлт: Төрийн сангийн дотоод зарлагын гүйлгээнд хяналт хэрэгжүүлээгүйгээс Өндөр-улаан сумын Хоршоо хөгжүүлэх сангийн эхний үлдэгдлээс анхан шатны баримтгүй 19.8 сая төгрөгийг хувь хүний дансанд шилжүүлснийг сумын ТТЗ-ийн аудитаар төлбөрийн акт тогтоож барагдуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.49-т "дотоод аудит" гэж төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн төсвийн дотоод хяналтын үйл ажиллагааг", 12 дугаар зүйлийн 12.1.16-т "төсвийн дотоод аудит, хяналт шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 7 дугаар зүйлийн 7.13-т дараах тохиолдолд зарлагын гүйлгээ гаргахыг хориглоно" 7.13.7. энэхүү журмын 7.8-д заасан анхан шатны баримт дутуу, иж бүрдэл болоогүй тохиолдолд" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн сангийн дотоод хяналтын 2024 оны төлөвлөгөөг аймгийн

Засаг даргаар батлуулж, биелэлтийг хангах, сумдын санхүү албаны дарга, төрийн сангийн мэргэжилтнүүдийн албан үүргийн хэрэгжилтийг шалгаж холбогдох арга хэмжээг авах

5.3.4 ДОТООД ХЯНАЛТ ХАРИУЦЛАГАТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

Илрүүлэлт: Хотонт сумын ЗДТГ, ИТХ, Цөм сүргийн үржлийн төв ОНӨААТҮГ нь 2023 оны санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд 8.9.1, 8.9.3, 8.9.8-д заасан хуулийн хугацаанаас хоцроосон, шаардагдах баримт материалыг иж бүрэн ирүүлж аудит хамруулаагүй бөгөөд эдгээр зөрчлүүд давтагдан гарсаар байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.49-т "дотоод аудит" гэж төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн төсвийн дотоод хяналтын үйл ажиллагааг", Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, 8.9.8 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Бүх шатны төсөв захирагчид, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг хуулийн хугацаанд төрийн аудитын байгууллагад хүргүүлсэн эсэхэд хяналт тавьж хуулийн хэрэгжилтийг хангаагүй тохиолдолд төсөв захирагч нарт хариуцлага тооцуулах саналыг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлж хэрэгжилтийг хангуулах

5.3.5 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ ТАЙЛАГНАЛТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

Илрүүлэлт: Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрууд нь "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг баталж мөрдөөгүйгээс бүртгэлийг зохих ёсоор хөтөлж санхүүгийн тайланг стандартын дагуу бэлтгэхгүй байх, хуулийн хугацаанд тайлагнахгүй байх зөрчлүүд давтагдсаар байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудад нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж мөрдүүлэх талаар нэгдсэн арга хэмжээ авч, бодлогын баримт бичгийг мөрдүүлэх замаар холбогдох хууль, стандартын хэрэгжилтийг хангуулах.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2024 оны 05 дугаарын 20-ны дотор ирүүлнэ үү.

Зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 01-ний дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

2. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Архангай аймгийн Засаг дарга	2	656.5			2	656.5	2	656.5		
Жаргалант сумын Засаг дарга	1	249.3	1	249.3			1	249.3		
Өндөр-Улаан сумын Засаг дарга	1	19.8			1	19.8	1	19.8		
Ар ус ундарга	3	84.0			3	84.0	3	84.0		
"Архангайд үйлдвэрлэв" ОНӨААТҮГ	2	2.3	2	2.3			2	2.3		
Өндөр-Улаан сумын ЗДТГ	1	3.6			1	3.6	1	3.6		
Өгийнуур сумын ЗДТГ	1	3.3	1	3.3			1	3.3		
Эрдэнэмандал сумын ЗДТГ	1	12.0	1	12.0			1	12.0		
ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН ИТХ	3	143.2			3	143.2	3	143.2		
Эрдэнэбулган сумын ЗДТГ	4	1,257.0			4	1,257.0	4	1,257.0		
Цэцэрлэг сумын ЗДТГ	1	7.9			1	7.9	1	7.9		
ЦЭНХЭР СУМЫН ИТХ	1	2.1	1	2.1			1	2.1		
Цэнхэр сумын ЗДТГ	1	12.3	1	12.3			1	12.3		
ХОТОНТ СУМЫН ИТХ	1	1.1			1	1.1	1	1.1		
Хотонт сумын ЗДТГ	2	179.1			2	179.1	2	179.1		
Хашаат сумын ЗДТГ	1	52.0	1	52.0			1	52.0		
ХАЙРХАН СУМЫН ИТХ	3	12.7			3	12.7	3	12.7		
Хайрхан сумын ЗДТГ	3	202.5			3	202.5	3	202.5		
ТӨВШРҮҮЛЭХ СУМЫН ИТХ	3	30.1			3	30.1	3	30.1		
Төвшрүүлэх сумын ЗДТГ	2	11.2			2	11.2	2	11.2		
Орон нутгийн өмчийн газар	4	236.1			4	236.1	4	236.1		
Байгаль орчин, аялал жуулчлалын газар	1	36.3			1	36.3	1	36.3		
Нийт дүн	42	3,214.4	8	333.3	34	2,881.1	42	3214,4		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Аймгийн Засаг дарга	7	308.8	-	-	2	308.8	5	-	-	-	-	-
Хашаат сумын Засаг дарга	1	12.4	-	-	-	-	1	12.4	-	-	-	-
Ихтамир сумын Засаг дарга	2	9.0	-	-	-	-	2	9.0	-	-	-	-
Төвшрүүлэх сумын Засаг дарга	3	23.7	-	-	1	-	2	23.7	-	-	-	-
Тариат сумын Засаг дарга	1	23.4	-	-	-	-	1	23.4	-	-	-	-
Хайрхан сумын Засаг дарга	2	20.0	-	-	-	-	2	20.0	-	-	-	-
Жаргалант сумын Засаг дарга	3	592.1	-	-	2	592.1	-	-	-	-	-	-
Хангай сумын Засаг дарга	1	10.1	-	-	-	-	1	10.1	-	-	-	-
Хотонт сумын Засаг дарга	3	137.5	-	-	2	53.9	1	83.6	-	-	-	-
Цахир сумын Засаг дарга	1	10.9	-	-	-	-	1	10.9	-	-	-	-
Цэнхэр сумын Засаг дарга	1	67.8	-	-	-	-	1	67.8	-	-	-	-
Цэцэрлэг сумын Засаг дарга	1	14.9	-	-	-	-	1	14.9	-	-	-	-
Эрдэнэбулган сумын Засаг дарга	3	43.0	-	-	1	-	2	43.0	-	-	-	-
Эрдэнэмандал сумын Засаг дарга	3	38.2	-	-	-	-	2	38.2	1	-	-	-
Өгийнуур сумын Засаг дарга	2	1.5	-	-	1	-	1	1.5	-	-	-	-
Өлзийт сумын Засаг дарга	1	256.1	-	-	1	256.1	-	-	-	-	-	-

Өндөр-Улаан сумын Засаг дарга	5	126.3	1	19.8	1	-	1	106.4	2	-	-	-
Батцэнгэл сумын Засаг дарга	1	6.6	-	-	-	-	1	6.6	-	-	-	-
Булган сумын Засаг дарга	2	5.6	-	-	1	-	1	5.6	-	-	-	-
Чулуут сумын Засаг дарга	1	5.1	-	-	-	-	1	5.1	-	-	-	-
Эрдэнэмандал сумын "Шилмэл сүргийн үржлийн төв" ОНӨААТҮГ	4	207.8	1	1.1	1	109.9	1	-	1	96.8	-	-
Эрдэнэмандал сумын "Ар саравч" ОНӨААТҮГ	1	-	-	-	-	-	-	-	1	-	-	-
Эрдэнэмандал сумын "Хөгжлийн дэд бүтэц" ОНӨААТҮГ	7	98.1	-	-	5	98.1	1	-	1	-	-	-
Архангай аймгийн "Цөм сүргийн үржлийн төв" ОНӨААТҮГ	1	-	-	-	-	-	-	-	1	-	-	-
Хайрхан сумын "Хөгжлийн дэд бүтэц" ОНӨААТҮГ	4	376.7	-	-	2	322.5	2	54.2	-	-	-	-
"Архангай орон сууц корпораци" ОНӨААТҮГ	1	0.3	-	-	1	0.3	-	-	-	-	-	-
"Ар ус ундарга" ОНӨХХК	8	67.7	1	0.6	5	67.1	2	-	-	-	-	-
"Чулуут ахуй үйлчилгээний төв" ОНӨААТҮГ	3	6.3	-	-	3	6.3	-	-	-	-	-	-
"Архангайд үйлдвэрлэв" ОНӨААТҮГ	5	20.4	1	2.1	2	7.0	2	11.3	-	-	-	-
Өндөр-Улаан сумын ИТХурал	4	4.6	-	-	3	4.6	1	-	-	-	-	-
Өндөр-Улаан сумын ЗДТГ	4	3.8	1	0.2	1	3.6	1	-	-	-	-	-
ӨЛЗИЙТ СУМЫН ИТХ	1	1.2	-	-	1	1.2	-	-	-	-	-	-
Өлзийт сумын ЗДТГ	3	36.3	-	-	3	36.3	-	-	-	-	-	-
Өгийнуур сумын ОНХСан	4	13.1	-	-	4	13.1	-	-	-	-	-	-
Өгийнуур сумын ЗДТГ	2	12.8	1	3.3	1	9.5	-	-	-	-	-	-
Өгийнуур сум СХСан	1	43.3	-	-	1	43.3	-	-	-	-	-	-
ЭРДЭНЭМАНДАЛ СУМЫН ИТХ	2	8.5	1	0.9	1	7.7	-	-	-	-	-	-
Эрдэнэмандал сумын ЗДТГ	4	16.7	1	2.8	3	13.9	-	-	-	-	-	-

ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН ИТХ	3	7.2	-	-	3	7.2	-	-	-	-	-	-
Эрдэнэбулган сумын ЗДТГ	7	47.8	2	11.7	5	36.1	-	-	-	-	-	-
Архангай аймгийн Цэцэрлэг хотын Захирагчийн дэргэдэх Хот тохижилт үйлчилгээний газар	4	6.5	1	4.9	2	1.6	1	-	-	-	-	-
ЧУЛУУТ СУМЫН ИТХ	1	7.4	-	-	1	7.4	-	-	-	-	-	-
Чулуут сумын ЗДТГ	2	3.1	-	-	2	3.1	-	-	-	-	-	-
Цэцэрлэг сумын ЗДТГ	2	17.8	-	-	2	17.8	-	-	-	-	-	-
ЦЭНХЭР СУМЫН ИТХ	3	1.9	1	0.6	2	1.3	-	-	-	-	-	-
Цэнхэр сумын ЗДТГ	4	63.0	1	1.0	3	62.0	-	-	-	-	-	-
ЦАХИР СУМЫН ИТХ	1	4.0	-	-	1	4.0	-	-	-	-	-	-
Цахир сумын ЗДТГ	5	132.9	1	0.9	4	132.1	-	-	-	-	-	-
Хотонт сум СХСан	1	87.6	-	-	1	87.6	-	-	-	-	-	-
Хотонт сумын ОНХСан	1	10.0	-	-	1	10.0	-	-	-	-	-	-
ХОТОНТ СУМЫН ИТХ	8	23.4	2	1.7	5	21.7	-	-	1	-	-	-
Хотонт сумын ЗДТГ	6	80.5	-	-	5	80.5	-	-	1	-	-	-
Хашаат сумын ЗДТГ	5	358.2	1	1.1	4	357.0	-	-	-	-	-	-
ХАНГАЙ СУМЫН ИТХ	2	2.0	-	-	2	2.0	-	-	-	-	-	-
Хангай сумын ЗДТГ	1	7.2	-	-	1	7.2	-	-	-	-	-	-
ХАЙРХАН СУМЫН ИТХ	2	0.9	-	-	2	0.9	-	-	-	-	-	-
Хайрхан сумын ЗДТГ	4	144.3	1	12.5	3	131.8	-	-	-	-	-	-
ТӨВШРҮҮЛЭХ СУМЫН ИТХ	3	10.4	-	-	3	10.4	-	-	-	-	-	-
Төвшрүүлэх сумын ЗДТГ	6	61.4	1	0.8	5	60.6	-	-	-	-	-	-
Тариат сумын ИТХурал	2	5.9	-	-	2	5.9	-	-	-	-	-	-
Тариат сумын ЗДТГ	2	5.1	-	-	2	5.1	-	-	-	-	-	-
ИХТАМИР СУМЫН ИТХ	2	11.4	-	-	2	11.4	-	-	-	-	-	-

Ихтамир сумын ЗДТГ	3	5.0	1	1.5	2	3.5	-	-	-	-		
ЖАРГАЛАНТ СУМЫН ИТХ	3	29.3	-	-	3	29.3	-	-	-	-		
Жаргалант сумын ЗДТГ	5	7.3	1	2.0	4	5.3	-	-	-	-		
БУЛГАН СУМЫН ИТХ	2	3.2	-	-	2	3.2	-	-	-	-		
Булган сумын ЗДТГ	2	2.5	1	2.5	1	-	-	-	-	-		
Батцэнгэл сумын ЗДТГ	2	2.3	-	-	2	2.3	-	-	-	-		
АРХАНГАЙ АЙМГИЙН ИТХ	3	105.2	-	-	2	98.3	1	7.0	-	-		
АРХАНГАЙ АЙМГИЙН ЗДТГ	7	40.2	1	2.3	6	37.9	-	-	-	-	-	-
Архангай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар	5	99.4	3	3.6	2	95.8	-	-	-	-	-	-
Архангай аймгийн санхүүгийн хяналт, аудитын алба	2	6.1	1	0.7	1	5.4	-	-	-	-	-	-
АРМӨНГӨН ЧАГНУУР	2	14.5	1	1.6	1	12.9	-	-	-	-	-	-
Аймгийн Мал эрсдлээс хамгаалах сан	1	7.4	-	-	1	7.4	-	-	-	-	-	-
АРМӨНХЖИН	1	1.0	-	-	1	1.0	-	-	-	-	-	-
АРМАНАЛ	2	13.7	1	3.3	1	10.4	-	-	-	-	-	-
НИЙТ ДҮН	218	4,067.4	29	83.7	141	3,332.3	39	554.6	9	96.8	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая

Байгууллагын нэр	Нийт зөрчил		төгрөгөөр/ Үүнээс								
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил											
Архангай аймгийн Засаг дарга	2	-			1	-				1	1
Төвшрүүлэх сумын Засаг дарга	1	-			1	-					
Эрдэнэбулган сумын Засаг дарга	1	-			1	-					
Жаргалант сумын Засаг дарга	1								1	1	
Өгийнуур сумын Засаг дарга	1	-			1	-					
Өндөр-Улаан сумын Засаг дарга	1	-			1	-					
Батцэнгэл сумын Засаг дарга	1	-			1	-					
Булган сумын Засаг дарга	1	-			1	-					
“Эрдэнэмандал шилмэл сүргийн үржлийн төв” ОНӨААТҮГ	1	-							1	1	
“Ар ус ундарга” ОНӨХХК	1	-			1	-					
“Чулуут ахуй үйлчилгээний төв” ОНӨААТҮГ	1				1	-					
"Архангайд үйлдвэрлэв" ОНӨААТҮГ	1	-							1	1	
Цэнхэр сумын ИТХ	1	-			1	-					
Цахир сумын ИТХ	1	-			1	-					
Цахир сумын ЗДТГ	1	-			1	-					
Хайрхан сумын ИТХ	1	-			1	-					
Төвшрүүлэх сумын ИТХ	1	-			1	-					
Төвшрүүлэх сумын ЗДТГ	1	-			1	-					
Ихтамир сумын ИТХ	1	-			1	-					

Жаргалант сумын ЗДТГ	1	-			1	-				
Булган сумын ИТХ	1	-			1	-				
Архангай аймгийн ИТХ	1	-					1	-		
Байгаль орчин, аялал жуулчлалын газар	1	-			1	-				
Санхүүгийн хяналт, аудитын алба	1	-			1	-				
“Ар Мөнгөн чагнуур” ЗБН	1	-			1	-				
“Ар Мөнхжин” ЗБН	1	-			1	-				
“Ар Манал” ЗБН	1	-			1	-				
Дүн	28	-			23	-	1	-	4	4
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Дүн										
Нийт дүн	28	-			23	-	1	-	4	4